



ХАН-УУЛ ДҮҮРГИЙН
ЭРҮҮЛ МЭНДИЙН ТӨВИЙН
ДАРГЫН ТУШААЛ

2017 оны 04 сарын 19 өдөр

Дугаар A/15

Улаанбаатар хот

Гемодиализийн баг байгуулах тухай

Эрүүл мэндийн сайдын 2015 оны 03 дугаар сарын 25-ны өдрийн 112 дугаар тушаал, 2017 оны 03 дугаар сарын 30-ны өдрийн A/119 тоот тушаалыг үндэслэн ТУШААХ НЬ:

1. Гемодиализийн багийг нэгдүгээр хавсралтаар, гемодиализийн багийн ажиллах журмыг хоёрдугаар хавсралтаар тус тус баталсугай.
2. Гемодиализ эмчилгээ, үйлчилгээний чанар, аюулгүй байдлыг ханган, тусламж үйлчилгээг чанартай, шуурхай үзүүлэхийг гемодиализийн багт даалгасугай.
3. Багийн үйл ажиллагаанд хяналт тавьж, мэргэжил арга зүйгээр ханган ажиллахыг хэвтүүлэн эмчлэх тасгийн эрхлэгч /З.Уранчимэг/-т даалгасугай.
4. Тушаалын хэрэгжилтэд хяналт тавьж ажиллахыг эмчилгээ эрхэлсэн орлогч дарга /Д. Сүнжидмаа/-д үүрэг болгосугай.


ДАРГЫН ҮҮРГИЙГ ТҮР
ОРЛОН ГҮЙЦЭТГЭГЧ



Э.БОДЬЦЭЦЭГ

170 70 0125

Хан-уул эрүүл мэндийн төвийн даргын
2017 оны ~~09~~ -р сарын ~~19~~ -ны өдрийн
8/15 дугаар тушаалын Нэгдүгээр хавсралт



ГЕМОДИАЛИЗИЙН БАГИЙН БҮТЭЦ

Багийн дарга:	Гемодиализийн эмч – З. Намуунбайгаль
Нарийн бичиг:	Диализийн сувилагч - Ц. Алтанцэцэг
Гишүүд:	Хоол зүйч - Л.Мэдэхгүй
	Сэтгэл зүйч – Э.Пүрэвсүрэн
	Диализийн техникч – Т.Ариунсэлэнгэ

Хан-Уул эрүүл мэндийн төвийн даргын
2017 оны 04 дүгээр сарын 19-ны өдрийн
А/15 дугаар тушаалын Хоёрдугаар хавсралт

ГЕМОДИАЛИЗИЙН БАГИЙН АЖИЛЛАХ ЖУРАМ

Нэг. Ерөнхий зүйл

1.1 Энэхүү журмаар гемодиализийн эмчилгээ, үйлчилгээний хүртээмж, чанар аюулгүй байдлыг ханган, бүртгэл мэдэээлийг сайжруулж, эрүүл мэндийн байгууллагын ажиллагсад, үйлчлүүлэгч, тэдний гэр бүл болон бусад иргэд эмнэлгийн тусламж үйлчилгээтэй холбоотой халдварт өртөхөөс урьдчилан сэргийлэх, эмнэлгийн тусламж үйлчилгээний чанар, аюулгүй байдлыг багийн үйл ажиллагаагаар зохицуулахад оршино.

1.2 Гемодиализийн баг нь Эрүүл мэндийн тухай хууль, Эм эмнэлгийн хэрэгслийн тухай хууль болон тэдгээрт нийцүүлэн гаргасан журам, стандарт, заавартай уялдуулан энэхүү журмыг мөрдөн ажиллана.

Хоёр. Гемодиализийн багийн чиг үүрэг

2.1 Гемодиализийн чиглэлээр мөрдөгдөж буй хууль, тогтоомж, журам, зааврын биелэлтийг хангуулан ажиллана.

2.2 Гемодиализийн эмчилгээ, үйлчилгээний тулгамдсан асуудлыг тодорхойлон эмчилгээ эрхэлсэн орлогч дарга болон удирдлагын зөвлөлийн хуралд санал оруулах

2.3 Гемодиализийн эмчилгээ, үйлчилгээний үйл ажиллагаанд шаардагдах төсвийг тодорхойлон шийдвэрлүүлэх

2.4 Гемодиализийн эмчилгээ, үйлчилгээний эрсдлийг бууруулах, урьдчилан сэргийлэхэд чиглэсэн арга хэмжээ, сургалтыг зохион байгуулах

2.5 Гемодиализийн эмчилгээ, үйлчилгээний тандалт, судалгааг тогтмол хийж халдварыг эрт илрүүлэх, мэдээллэх, хариу арга хэмжээг оновчтой зохион байгуулах

2.6 Эрүүл мэндийн ажилтныг халдварт өртөх эрсдэлээс сэргийлэх арга хэмжээг авч ажиллах

2.7 Эмнэлгийн багаж хэрэгсэл, тоног төхөөрөмж, ариун цэврийн бүтээгдэхүүн, хувийн хамгаалах хувцас хэрэгслийн тооцоог гарган, халдвар хамгааллын дэглэмийг чанд мөрдөн ажиллана.

Гурав. Гемодиализийн багийн гишүүдийн чиг үүрэг

3.1 Гемодиализийн багийн эмчийн чиг үүрэг:

- Гемодиализийн багийн үйл ажиллагааг удирдан зохион байгуулна.
- Гемодиализ эмчлэгч эмч нь долоо хоногт эмчилгээнд орох сеансын тоог тогтоохдоо батлагдсан эмчилгээ, оношилгооны зааврын дагуу эрүүл мэндийн

үзүүлэлтүүдийг үндэслэн үнэн зөв оновчтой шийдвэрлэн, эмчилгээний үр дүнг тооцож, анхан шатны бүртгэлийн маягтаар баталгаажуулах

- Гемодиализийн өвчтөн үзэх, судсыг ажиглах
- Гемодиализ эмчилгээний хуудсыг бөглөж, сувилагчид арга зүйн зөвлөгөө өгөх
- Гемодиализ эмчилгээний үеийн хүндрэл гарахад оношлон арга хэмжээ авах
- Төлөвлөгөөт архаг Гемодиализ эмчилгээний явц, үр дүнг хянаж, ажиглах
- Яаралтай болон төлөвлөгөөт журмаар хийгдэх Гемодиализ эмчилгээний талаар өвчтөн, ар гэрт танилцуулж, зөвшөөрөл авч, баталгаажуулах
- Иргэний шилжилт хөдөлгөөн болон бусад шалтгаанаар эмнэлгийн харьяалал өөрчлөгдөж, шилжүүлэх шаардлагатай болсон иргэнийг хуанлийн 21 хоногийн өмнө хүлээн авах эмнэлэгт нь урьдчилан мэдэгдэж, бүртгэлд орсны дараа шилжүүлнэ.
- Ажилбарын үеийн халдвар хамгаалалын дэглэмийн дагуу ажиллаж, хяналт тавин ажиллах
- Усны сорьцын нян судлалын шинжилгээг сар тутам, химийн шинжилгээг улирал тутам тогтмол шинжлүүлсэн байх
- Гемодиализ эмчилгээний багт ажиллаж буй сувилагч, инженер, техникч нарт хяналт тавих
- Гемодиализ эмчилгээний улирлын тайлангийн маягтын дагуу улирал тутам мэдээлэлийг гаргаж, дараа улирлын эхний сарын 04-ны өдрийн дотор Эрүүл мэндийн хөгжлийн төвийн Статистик мэдээлэлийн технологийн албанд цахим хэлдбэрээр хүргүүлнэ.
- Хууль, дүрэм, журам, стандарт, эмнэлзүйн зааврын биелэлтэнд хяналт тавьж ажиллах
- Өвчтний эрхийг хамгаалах
- Эмчилгээнд хамрагдаж байгаа үйлчлүүлэгчдэд тогтмол хэрэглэх эм, өвчтөн, ар гэрийн хүмүүст сэтгэлд нийцсэн лавлагаа, сэтгэлд нийцсэн зөвлөгөө өгөх удирдамжийн дагуу сургалт зохион байгуулах, зөвлөгөө өгөх
- Мэргэжлийн хурал, зөвлөгөөнд жилд 1-2 удаа оролцож тасралтгүй сургалтанд хамрагдах

3.2 Гемодиализийн багийн сувилагчийн чиг үүрэг:

- Аппарат, тоног, төхөөрөмжийн бэлэн байдлыг хангах
- Эд, аж ахуйн хэрэгслийн бүрэн бштэн байдлын хянах, захиалах
- Яаралтай тусламжийн болон эмийн шүүгээний бэлэн байдлыг ханган ажиллах
- Аппарат ажилуулахад бэлтгэж, тохиргоо хийх, шаардлагатай төхөөрөмж, эм, диалезийн хэрэгслийг бэлдэж тавих
- Бичиг баримт, хяналтын хуудсыг хөтлөх
- Эмчлүүлэгчийн амин үзүүлэлт, биеийн жингийн индексийг үзэж тэмдэглэгээ хийх
- Үйлчлүүлэгчдээ гемодиализ эмчилгээний явцын талаар тайлбарласны дараа диализийг эхлүүлэх
- Үйлчлүүлэгчдэд судас болон гуурсыг хэрхэн хамгаалах талаар зөвлөгөөг өгөх

- ГДЭ-г эмчийн хяналтанд удирдаж явуулах
- ГДЭ хийх судасны хүрц болон байрлалыг тодорхойлж тэмдэглэл хөтлөх
- ГДЭ-ний дараахь амин үзүүлэлтийг тодорхойлж, хяналт тавих
- Аппаратны үндсэн цэвэрлэгээг хийх
- Жилд нэг удаа мэргэжлийн сургалтанд хамрагдах

3.3 Гемодиализийн багийн инженер, техникчийн үүрэг

- Гемодиализийн эмчтэй хамтран ажиллах
- Гемодиализийн техникч нь аппарат, тоног төхөөрөмжийн тохиргоо болон бэлэн байдлыг хангах
- Гемодиализийн усны системийн бүрэн бүтэн байдал, аюулгүй ажиллагааг ханган ажиллах
- Гемодиализийн аппаратны үндсэн филтерийн ажиллах хугацааг тогтмол шалгах
- Технологийн дэвшлийн талаар мэдээлэлийг тасгийн эмч, мэргэжилтэн ажилтнуудад хүргэх
- Багаж, тоног төхөөрөмжийн хэвийн ажиллагааг ханган ажиллах, урьдчилан сэргийлэх арга хэмжээг төлөвлөн ажиллах
- Төлөвлөгөөт үзлэгийг зохион байгуулж, тоног төхөөрөмжийн ашиглалтын паспортыг хөтлөх
- Багаж, тоног төхөөрөмжийн шинэчлэл, хагамжийг судлан хэрэгжүүлэх
- Жилд нэг удаа мэргэжлийн сургалтанд хамрагдах

3.4 Гемодиализийн багт ажиллах хоол зүйчийн чиг үүрэг

- Гемодиализ хийлгэж буй өвчтөн бүрт хоолны жор зохиож, хэрэглээнд хяналт тавьж ажиллах
- Хоол тэжээлийг нөхөх эмчилгээний төлөвлөгөө гарган арга зүйн зөвлөгөө өгөх
- Хоолны хордлого зэрэг элдэв эрсдлээс сэргийлж, эрүүл ахуй, ариун цэврийн шаардлагыг чанд сахиулах
- Тухайлсан өвчтний хоолны жор, найрлага, орц тэргүүтнийг хянах

3.5 Гемодиализийн багт ажиллах нийгмийн ажилтны чиг үүрэг

- Өвчтний ахуй байдалд ерөнхий үнэлгээ өгөх
- Өвчтөн, түүний ар гэрт нийгмийн халамж, тусламжийн чиглэлээр мэдээлэл өгөх
- Өвчтнийг нийгэмшихэд туслалцаа үзүүлэх
- Өвчтний нийгмийн халамж үйлчилгээ, ахуй амьдрал, аж төрөх заншил, хэвшлийг онцгойлон анхаарах

Дөрөв . Хүлээх хариуцлага

4.1 Холбогдох хууль тогтоомж, энэхүү журмаар тогтоосон хэм хэмжээг зөрчсөн албан тушаалтанд холбогдох хариуцлагыг ногдуулна.